

Судлаач сонсогч

ХОРИХ АНГИД ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ТӨЛБӨР ТӨЛӨГЧӨӨС ТӨЛБӨР
ГАРГУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГFEATURES OF THE EXECUTION OF THE DECISION TO COLLECT
PAYMENT FROM THE PAYER WHO IS SERVING A SENTENCE IN
PRISON**Б.Анун***Дотоод хэргийн их сургуулийн**Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн**541 дүгээр дамжааны ахлах түрүүч*

Товч утга: Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүр өөр өөрийн гэсэн онцлогтой бөгөөд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааны онцлог нь хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлэн, цалинжуулж хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж хохирогчийн эрх ашгийг хамгаалах юм.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн хохирлыг барагдуулах гэм буруутан нь хорих ялаар шийтгэгдсэн гэх шалтгаанаар хохирогчийн сэтгэл санаа, эрүүл мэнд бусад хохирлын төлбөрийг төлөхгүй байж болохгүй бөгөөд харин ч цаг алдалгүй хохирлыг барагдуулах нь чухал. Гэвч хорих ял эдэлж буй хоригдлууд нь мөнгөн хөрөнгө, эд хөрөнгөгүй, дансан дахь хадгаламжгүйгийн улмаас хорих ангийн үйлдвэрт ажиллаж хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгуулах боломжтой болдог.

Хоригдол нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждагаас шалтгаалан суутгал нь маш бага багаар төлөгддөг учраас төлбөр барагдуулахад хугацаа их шаарддаг. Тиймээс энэ ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байгаа учир судлаач миний бие олон төрлийн судалгаа авч эрх зүйн түүхэн уламжлал болон өнөөгийн байдалтай харьцуулан шийдвэрлэх арга замыг эрэлхийлж санал зөвлөмжөө энэхүү өгүүлэлдээ тусгасан.

Түлхүүр үгс: Төлбөр төлөгч, төлбөр авагч, хохирогч, хохирол, хөдөлмөрийн хөлс, хөдөлмөр, төлбөр гаруулах ажиллагаа, хөрөнгө.

Abstract: Each decision enforcement process has its own characteristics, and the feature of the process of collecting payment from the payer who is serving a sentence

in the prison is to protect the rights of the victim by raising the prisoner with labor and paying him a salary.

Restitution to the victim of crime should not be done without paying for other damages due to the fact that the perpetrator has been sentenced to prison, and it is important to pay the damages without delay.

However, due to the fact that prisoners serving prison terms do not have money, assets, or savings in their accounts, they can work in prison factories and have monthly deductions from their wages. Because inmates are paid the minimum wage, deductions are paid in small increments, so it takes a long time to pay off. Therefore, due to the fact that the Court's execution organization needs to pay attention to this process, the researcher took five types of research, compared the legal historical tradition and the current situation, and found solutions in this article.

Keywords: Imprisonment, Payor, Payee, Victim, Damages, Wages, Labor, Settlement, Assets

Эрх зүйт төр нь хууль дээдлэх, төр, иргэний харилцан үүрэг хүлээх, хүний эрх, эрх чөлөөг хангах зэрэг зарчмыг баримтлахынхаа хүрээнд иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механезмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэх, арилгах буюу нөхөн төлүүлэх асуудлыг хуульчлан зохицуулсаар ирсэн. Хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээж буй этгээдийн нэг нь хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч юм.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч нь гэдэг нь нь ялын хамгийн хатуу төрөл болох хорих ял эдлэх хугацаандаа бусдад учруулсан гэм хор, хүүхдийн тэтгэлэг, бусад төлбөрийг төлөх үүрэг хүлээж буй хоригдол юм. Тэгвэл хорих ангид ял эдэлж буй хоригдол ямар тохиолдолд төлбөр төлөгч болох вэ?

- Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй
- Хохирогчид гэм хорын хохирлын төлбөрийг олгоогүй гэх тохиолдлуудад

Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь ямар нэгэн дур зоргийн шинжтэй байж болохгүй. Энэхүү шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай нарийн судлахын тулд хорих ял, хорих анги, төлбөр төлөгч, төлбөр авагчийн тухай ойлголтыг товчхон дурдах нь логик дарааллын хувьд оновчтой юм.

Ял нь латины “punitas” болон “reina”- цээрлэл залхаалт буюу гэмт үйлдлийн золиос, гэмт гарзын төлөөс гэсэн язгуур утгаас эх үндэстэй бөгөөд гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь нотлогдсон этгээдийг төрөөс цээрлүүлэх хэрэгсэл, гэмт этгээдийн хувьд гэмт хэрэг үйлдсэний өр төлөөс, үр дагавар юм.¹⁶⁶

¹⁶⁶ С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть” УБ., 2014 он

Ялын зорилго нь гэмт этгээдийг дахин бусдад хор уршиг учруулахад саад хийх, ахин хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх юм. Ялын зорилгыг тусгайлан судалсан эрдэмтэд, судлаачдын дийлэнх нь ял нь ялтныг хүмүүжүүлэх, түүнийг гэмт хэрэг дахин үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх эрүүгийн ялын зорилтыг хангахад чиглэгдсэн хүмүүжлийн нөлөө үзүүлэх гэж үздэг.

Ялын онолыг ерөнхийд нь авч үзвэл дэлхийн улс орнуудад абсолют болон харьцангуй онолыг голчлон баримталдаг.

Абсолют онолын гол агуулга нь “Хохирлыг хохирлоор”, “Гэмтнийг гэсгээлээр” гэсэн үндэслэгээ, зарчимд тулгуурлан, гэмт хэрэг хийсэн этгээдийг төрөөс /хашраах/ яллан цээрлүүлэх, гэмт хэрэгт нь тохирсон ялыг оноох, шаардлагыг хангахад чиглэгддэг.

Харин харьцангуй онол буюу ялыг нийгэмшүүлэх хандлага /Ж.Руссо, М.Вебер/ XX зууны II хагасаас эхлэн абсолют онолыг шүүмжлэх хандлага баруун Европт хүчтэй дэлгэрч, ялын зорилго нь ялтныг нийгмээс тусгаарлаж, залхаан цээрлүүлэхэд гол нь биш, харин эргээд нийгмийн амьдралд хөлөө олоход нь туслах, засч төлөвшүүлэх замаар нийгэмшүүлэхэд чиглэгдэх ёстой¹⁶⁷ гэж үзжээ.

Үүнээс үзэхэд засч төлөвшүүлнэ гэдэг нь хорих ангид хоригдож буй хоригдлыг хүмүүжүүлэх ойлголттой ижил утгатай юм.

Хоригдлыг хүмүүжүүлэх үед түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг бүрэн дүүрэн ухамсарлуулах, сургалтаар болон хөдөлмөрөөр хүмүүжүүлэх нь үр нөлөө сайтай хэмээн судлаачид үздэг.

Хоригдлыг сургалтаар хүмүүжүүлэхэд ерөнхий боловсролын сургалт, мэргэжил эзэмшүүлэх сургалт, зан үйлд нөлөөлөх албадан сургалтаар хүмүүжүүлдэг. Гэхдээ зөвхөн сургалтаар хүмүүжүүлэх нэг талын үзэл баримтлалаар хүмүүжүүлнэ гэдэг нь өрөөсгөл бөгөөд аль ч улс орон, хувь хүний оршин тогтнохын эх сурвалж болсон хөдөлмөрөөр хүмүүжүүлэх сонгодог жишээг дурдахгүй байж болохгүй.

Оросын эрүүгийн эрх зүйн онолыг үндэслэгчид А.А.Пионтковский, М.Д.Шаргородский, И.Е.Ной С.В.Полубинская нар ялын зорилго бол цээрлүүлэлт биш, харин энэ нь ялын мөн чанар, агуулга бөгөөд ялтанд эхлээд итгүүлж үнэмшүүлэх дараа нь албадах аргыг хэрэглэх шаардлагатай гэсэн энэрэнгүй үзлийг баримталдаг.¹⁶⁸

Монгол улсын хувьд ч хорих ял нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд томоохон байр суурь эзэлдэг бөгөөд 2015 оны эрүүгийн хуулиар буюу ялын бодлогод хоригдлыг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх нийтлэг зорилгод хөдөлмөрлүүлэх ач холбодлыг тусгасан.

Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх үндсэн ба хамгийн хатуу ялын төрөл болох хорих ял нь (англ. Deprivation of liberty)-гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх

¹⁶⁷ Д.Баярсайхан. Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал., 2012 он

¹⁶⁸ А.А.Пионтковский. Основные аспекты теории наказания. 1963., 25 дах тал

чөлөөг тодорхой хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж, нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад хүмүүжүүлэх юм. Эл ялыг хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд шүүх оногдуулах бөгөөд эрүүгийн хууль ба шүүхийн практикт өргөн хэрэглэгддэг.¹⁶⁹

Хорих ял нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой хугацаагаар нь хугацаатай, хугацаагүй гэж ангилна. Хугацаатай ял нь 6 сараас 20 жил, хугацаагүй ял нь бүх насаар нь хорих юм. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн 25 жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэдэг. Хэрэв суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ. 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн бол бүх насаар хорих ял оногдуулахгүй.

Хорих анги нь төвлөрсөн бүтэцтэй байх бөгөөд нээлттэй, хаалттай, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.

Хорих ял эдэлж байгаа ялтныг хоригдол гэнэ.¹⁷⁰ Хоригдол нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар 15 эрх 9 үүрэгтэй.

Хоригдлын үүргүүдээс хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх аргад нийцэх нь Хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих юм. Ажил хөдөлмөр эрхэлж хохирогчид учруулсан хохирлыг төлөх нь хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн үндсэн үүрэг юм.

Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг хэлнэ.¹⁷¹

Хорих ангид хорих ял эдэлж буй төлбөр төлөгчийн бусдад учруулсан хохирол нь үйлдсэн хэрэг, бусдад учруулсан гэм хороос шалтгаалан шүүхээс өөр өөрөөр тогтоогдсон байдаг. Хохирогч нь шүүхийн шатанд хохирогч гэж нэрлэгдэж байсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр авагч гэж нэрлэгддэг.

Төлбөр авагч нь хохирол нөхөн төлбөрөө төлбөр төлөгчөөс нэхэмжлэх эрхтэй бөгөөд эрх хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн хуулийн этгээд байна. Хохирогч буюу төлбөр авагчийн хөндөгдсөн эрх, ашгийг нөхөн сэргээх, хохирол төлбөрийг нөхөн төлүүлэх нь төрийн үүрэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд бусдад учруулсан хохирлоо бүрэн барагдуулах нь эрх зүйт төрийн шударга ёсонд нийцнэ.

¹⁶⁹ С.Нарангэрэл. Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. 2021., 491 дэх тал

¹⁷⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл

¹⁷¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл

Иймд хохирогчийн буюу төлбөр авагчид учруулсан гэм хорын хохирлыг хэрхэн түргэн, шуурхай төлж барагдуулах арга замыг тодорхойлох нь энэ цаг үед нэн чухал байгаа тул хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд онцгой анхаарах шаардлагатай байна.

Хорих ял эдэлж буй хоригдлын төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх тухай мэдэгдлийг ял эдэлж байгаа хорих ангийн захиргаанд хүргүүлнэ.¹⁷² Гэхдээ зөвхөн хорих ангийн захиргаанд даатгах бус шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалтыг зөрчилгүй ажиллагааг явуулах нь зүйтэй.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч нь иргэн юм. Иймд төлбөр төлөгч-иргэний мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааны дарааллаар бусдад учруулсан гэм хорын төлбөрийг төлүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, бусад үнэт зүйлээс төлбөрийг гаргуулна.¹⁷³ Төлбөр төлөгч-иргэнд мөнгөн хөрөнгө байхгүй эсхүл мөнгөн хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн өмчлөлийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс гаргуулна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн төлбөр төлөлтийн талаарх сүүлийн 3 жилийн бодит биелэлтийн мэдээг дараах байдлаар боловсруулав.

2020-2023 оны Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчид холбогдох гүйцэтгэх баримт бичиг

	2020 он	2021 он	2022 он	2023 он эхний улирал
Гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх баримт бичгийн тоо	1902	1383	1621	1522
Гүйцэтгэвэл зохих гүйцэтгэх баримт бичгийн төлбөрийн хэмжээ	77,365,272.5	89,705,709.0	107,290,955.5	109,158,166.5
Дуусгавар болсон гүйцэтгэх баримт бичгийн тоо (хувь)	390 буюу 20.5%	299 буюу 21.6%	294 буюу 18.1%	74 буюу 4.8%

¹⁷² Шийдвэр гүйцэтгэгчийн ном

¹⁷³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл

Дуусгавар болсон гүйцэтгэх баримт бичгийн төлбөрийн хэмжээ (хувь)	1,244,592.3 буюу 1.6%	1,478,392.6 буюу 1.6%	2,054,177.1 буюу 1.8%	396,862.109 буюу 0.4%
---	--------------------------	--------------------------	--------------------------	--------------------------

Дээрх хүснэгтээс дүн шинжилгээ хийхэд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь үр дүн муутай бөгөөд бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлтээс 3 дахин бага үзүүлэлттэй байна. Иймд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн төлбөрийг төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд цаашлаад хохирогч буюу төлбөр авагчийн хохирлыг барагдуулахад онцгой анхаарах шаардлагатай байгааг тодорхой харуулж байна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэхийн тулд судлаач миний бие дараах 5 төрлийн судалгааг авч боловсрууллаа.

Нэгдүгээрт: Хөдөө орон нутгийн 45, нийслэлийн 55 шийдвэр гүйцэтгэгчээс Google form ашиглан санал асуулгын аргаар 16 асуулга бүхий судалгааг (Хавсралт 1) авахад:

1. Нэг шийдвэр гүйцэтгэгчид дунджаар 100-200 хүртэлх гүйцэтгэх баримт бичиг гар дээр ажиллагаатай байгаа бөгөөд үүнээс ердөө 10% хүрэхгүй хувийг Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаатай гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна.

2. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчдийн 10% хүрэхгүй хувь нь мөнгөн хөрөнгө, эд хөрөнгөгүй учраас төлбөрийн мөнгийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгахаас өөр сонголтгүй болж байна. Хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын хөдөлмөрийн хөлсний үнэлэмж бага байгаагаар холбоотойгоор хохирол, төлбөрийг төлүүлэх ажиллагаа нь урт хугацаа шаардаж байна. Мөн төлбөртэй хоригдол бүр ажлын байраар хангагдах боломж бага байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

3. Хорих ял эдэлж буй төлбөр төлөгч төлбөрөө ямар хугацаанд төлдөг вэ? гэх асуултанд 10% нь 5-аас дээш жил, 32% нь сар бүр хөдөлмөрийн хөлснөөс суутгадаг, 58% нь хугацаанаас өмнө суллагдахдаа гэж хариулжээ. Үүнээс үзэхэд төлбөр төлөгч хорих ялын хугацаанаас өмнө суллагдах зорилгоор төлбөрийг төлж барагдуулах хандлага давамгайлж байна.

4. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчид ямар гэмт хэрэгт холбогдсон байна вэ гэх асуултад 46% нь хулгайн гэмт хэрэг, 52% нь залилах гэмт хэрэг үйлдсэн гэж хариулсан ба дээрх гэмт хэргийн хохирогчдын тоо их бөгөөд төлбөрийн хэмжээ өндөр байдаг онцлогтой. Мөн гэм хорын хохирол, төлбөрөөс гадна хүүхдийн тэтгэлэг төлбөртэй хоригдлууд нийлээдгүй хувийг эзэлж байна.

Дээрх асуудлуудаас гадна шийдвэр гүйцэтгэгч нараас нээлттэй санал асуулга авахад Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчдөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хамгийн хүндрэлтэй зүйлс нь төлбөр төлөгч өөрийн гэсэн мөнгөн хөрөнгө, орлого, эд хөрөнгөгүй байдал байдаг талаар хариулсан байна. Мөн хоригдлууд ажлын байраар хангагдсан ч цалин хөлс нь бага байдаг учир ажиллагаа маш удаан явагддаг гэсэн байна. Ер нь хорих ял эдлэгдсээр хөдөлмөр хийлгэж, түүнээс тооцогдох цалингаас ялтны иргэн, байгууллагад учруулсан хохирлыг барагдуулах ажил үр дүн муутай явж ирснийг олон арван жилийн түүхт байдал харуулдаг билээ.¹⁷⁴

Хоригдлын хөдөлмөрлөх эрхийг хангаж, хохирол төлбөрийг төлөх боломжийг олгож байгаа нь сайшаалтай боловч түүний хөдөлмөрийн хөлсний үнэлгээ буюу цалин, хөлс нь бага байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах гол хүчин зүйл болж байна. Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл эдэлж байгаа хэдий ч энгийн иргэнтэй яг адилхан ажиллаж, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх эрх тэдэнд бий. Тиймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 215.1 дэх заалт болох “хоригдлын хийсэн хөдөлмөрт нь тооцож хөлс олгоно” гэсэн заалтын дагуу хоригдлуудыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах явдал практикт өргөн хэрэглэгдэж байна.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч бүгд ажлын байраар хангагдаж чадсан уу? гэх асуултад шийдвэр гүйцэтгэгчид Зан байдлын төлөвлөөс шалтгаалаад бүгд хамрагдаж чаддаггүй гэж хариулжээ. Учир нь Хорих ангийн нийгмийн ажилтан зан байдлын төлөвшлийг тодорхойлохдоо зөвхөн хорих ангид ирэхэд нь ярилцаад тодорхойлчихдог. Үүний оронд хохирлын төлбөрөө төлөх заавал шаардлагатай хорих ангид цалинтай ажил хийхийн давуу талыг хоригдолд тайлбарлан өгч хоригдлын ажиллаж хөдөлмөрлөх сэтгэл зүй, зан байдлыг өөрчилж өгөх хэрэгтэй. Мөн хорих ангийн захиргаа төлбөртэй хоригдлыг заавал цалинтай ажил хийлгэх шаардлагатай бөгөөд үүнийг холбогдох хууль журманд тусгаж өгөх нь хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчдөөс төлбөр гаргуулах ажиллагаанд маш чухал нөлөө үзүүлэх юм.

Хоёрдугаарт: 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн хоригдол Б.Н-тэй ярилцаж (Хавсралт 2) ярилцлагын аргаар судалгаа авахад:

Тэрээр залилах гэмт хэрэг үйлдсэн бөгөөд хохирогч олонтой бөгөөд нийт 395.875.050 төгрөгийн гэм хорын төлбөртэй. Хорих ангид ажлын байраар хангагдаж цалинтай ажил хийж гэм хорын төлбөрөө суутгуулдаг. Гэвч түүнтэй ярилцаж үзэхэд цалингийн 70%-иар суутгуулан төлбөрөө төлдөг ч ял эдэлж байх хугацаандаа төлбөрөө төлж барагдуулах ямар ч боломж байхгүй, магадгүй ажил хийснээрээ цаг хурдан өнгөрдөг тул ажил хийхээр шийдсэн гэж хариулж байв. Үүнээс харахд хорих ял эдлүүлэх хугацаанд хоригдолыг хөдөлмөрөөр

¹⁷⁴ Лхагва, М.Ганхүү. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Уб.2015 он. 176 дахь тал

хүмүүжүүлэх зорилго хангагдахгүй байна гэж үзэж болохоор байна. Учир нь хоригдол ажил хийхийг зөвхөн цаг нөхцөөх арга хэрэгсэл хэмээн ойлгож хүлээж авч байгаа нь ардаа хохирол төлбөрийг төлөх, хохирогчийн эрх ашгийг хангах, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах бусад зорилгыг үнэгүйдүүлж байгаа хэрэг юм.

Гуравдугаарт: Сүүлийн 3 жилд хорих ангид ял эдэлж буй төлбөртэй хоригдлын төлбөрөө хэрхэн төлж барагдуулсан талаарх мэдээллийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан дахь Төлбөртэй хоригдлын мэдээнээс үзвэл:

2020 оны байдлаар нийт төлбөртэй 1902 хоригдлын 77,365,272.5 төгрөгөөс 79% буюу 1512 хоригдлын 75,857,684.2 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 18% буюу 336 хоригдлын 1,214,547.9 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдөж 3% буюу 54 хоригдлын 30,017.8 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан.

2021 оны байдлаар нийт төлбөртэй 1383 хоригдлын 89,705,709.0 төгрөгөөс 78% буюу 1084 хоригдлын 87,551,162.9 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 21% буюу 277 хоригдлын 1,457,689.5 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдсөн 1% буюу 22 хоригдлын 20,703.1 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан.

2022 оны байдлаар нийт төлбөртэй 1621 хоригдлын 107,290,955.5 төгрөгөөс 85% буюу 1327 хоригдлын 104,889,917.2 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 14% буюу 252 хоригдлын 2,032,502.6 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдөж 1% буюу 42 хоригдлын 21,647.5 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт төлбөртэй 1522 хоригдлын 109,158,166.5 төгрөгөөс 95% буюу 1448 хоригдлын 108,693,151.3 төгрөгийн төлбөр бүрэн төлж барагдаагүй 5% буюу 69 хоригдлын 395,629.109 төгрөгийн төлбөр хоригдлын ар гэрээс төлөгдөж. Харин ердөө 0.5% буюу 5 хоригдлын 1,233.0 төгрөгийн төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс төлж барагдуулсан байна.

Энэхүү судалгаанаас үзэхэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байх зарчим алдагдаж харагдаж байгаа бөгөөд хамгийн ихдээ 2021 онд 22%-ийн бодит биелэлттэй байна. Энэ нь нэг талаас хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал бөгөөд нөгөө талаас нийт төлөгдсөн төлбөрийн ихэнх хувь нь хорих ангид ял эдэлж буй хоригдлын төлбөрийг ар гэрээс нь төлсөн байна. Энэ нь эрүүгийн хуулийн 1.3.3 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй” гэх заалтыг зөрчиж байгаа юм.¹⁷⁵

¹⁷⁵ Эрүүгийн хууль. Уб., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл

Дөрөвдүгээрт: Монгол улсын Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн түүхийн асуудлыг Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Авирмэдийн Лхагва тусгайлан судалж энэ чиглэлээр олон арван бүтээл туурвиж¹⁷⁶ байсан бөгөөд судлаачийн хувьд Хорих ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалт, түүний цалин хөлсний асуудлыг салбарын 1931, 1966, 1981, 1995, 1996, 1999, 2002 оны хуулийн хүрээнд түүхэн эх сурвалжаас түүвэрлэн авч үзлээ.

-1931 оны “Монгол ард улсын дотор Аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах тухай хууль-ийн 4 дүгээр зүйлд Хөлсөөр ажил хийж буй хоригдогсдод нэжгээд дэвтэр олгож, түүнд төлөхөөр тогтоосон ба хөлс олгосон, жич суутгаж авсан хөлс, шагналын зүйлс хичнээн болохыг тэмдэглэвэл зохино.

Хуулийн 29, 30-р зүйлд

-зууны 25 хувиас доошгүйг ажил хийсэн хоригдогсдод

-зууны 25 хувийг улсын санд оруулах

-50 хувийг цэвэр ашиг болгон хуваарилна гэжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар зарлигаар батлагдсан БНМАУ-ын “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”-ийн 3 дугаар бүлгийн 25 дугаар зүйлд “Хоригдол нь ял эдэлж байх үедээ өөрийн буруугаас улсад учруулсан эд материалын үнийг төлүүлнэ”,

-1981 оны “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”-ийн 38 дугаар зүйлд “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, гянданд хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөрийн хөлснөөс ажлын тусгай хувцас, тусгай хоолны үнээс бусад хоол хүнсний болон хувцас, цагаан хэрэглэлийн үнийг суутгана. Хөдөлмөрийн хөлснөөс энэ суутгалыг хийсний дараа гүйцэтгэх хуудас болон бусад гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд заасан журмын дагуу суутгал хийнэ”, гэж заасан нь гүйцэтгэх хуудас болон гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийн хэмжээгээр суутгал хийнэ гэж заасан.

-1995 оны “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль”-ийн 17 дугаар зүйлд “Цалин хөлснөөс суутгасан мөнгийг гүйцэтгэх хуудас байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд шилжүүлнэ” гэжээ энэ нь хорих ангиудын захиргаа нь энэ цаг үеэс хорих ял эдэлж буй хоригдлын бусдад учруулсан хохирлыг барагдуулахад түргэн шуурхай ажиллаж эхэлжээ.

-1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль-ийн 61 дүгээр зүйлд “Хөдөлмөрийн хөлснөөс суутгасан мөнгийг гүйцэтгэх хуудас байгаа шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын дансанд шилжүүлнэ” гэдэг нь шинэ ойлголт нэмэгдсэн байх бөгөөд хөдөлмөрийн хөлснөөс суутгах гэж заажээ. Иймд хоригдлууд хөдөлмөрлөснөөр хөдөлмөрийнхөө тоо, чанарт тохирсон хөлс авах боломжтой болсон байна.

¹⁷⁶ Л.Чүлтэмсүрэн, А.Лхагва “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар ”

- 2002 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 121 дүгээр зүйлд Хорих ангийн ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогчоос шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг нь ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ. Хорих анги, эсхүл ажил олгогч нь ялтны хөдөлмөрийн хөлсийг тухайн үеийн үнэлгээ, ханшаар тооцно¹⁷⁷ гэж хуульчилж ирсэн. Тэгэхээр хоригдлын хөдөлмөрийг үнэлэх үнэлгээ нь хийж буй ажил ажлын гүйцэтгэлээсээ шалтгаалаад өөр байжээ.

Түүхэн дэх хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлсээр ирсэн түүхэн эх сурвалжууд байна. Мөн төлбөр авагчийн эрхийг хангах талаар хууль тогтоомжид тусгаж өгч төлбөр авагчийн эрх байр сууринд 1996 оноос хойш түлхүү анхаарал хандуулж иржээ.

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь өнөөгийн байдлаар Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллагааг явуулдаг. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Хорих ял эдэлж байгаа хоригдлын төлбөрийг хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж, иргэний шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст шилжүүлнэ” гэсэн заалт ерөнхийлөн энэ төрлийн харилцааг зохицуулж байна.

100 жилийн түүхт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаан дахь асуудлуудыг дотооддоо шийдэх боломжтой байтал хамтарч ажиллаж чаддаггүй, энэ төрлийн ажиллагааны үр дүнд анхаардаггүй, хамтын ажиллагаа муутай байгаагийн илрэл юм. Жишээ нь төлбөртэй хоригдлуудыг анхаарч бүгдийг нь ажлын байраар хангадаггүй, цалин хөлсгүй ажил буюу хорих ангийн аж ахуйн ажил, бусад ажлуудад хуваарилдагтай шууд холбоотой гэж үзэхээр байна.

Хэдийгээр үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон ялыг буюу хорих ялыг оногдуулсан хэдий ч ард нь бусдад учруулсан гэм хорын асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарах шаардлагатай юм.

Хамгийн гол нь хохирч үлдсэн хүний эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг тэргүүн ээлжинд авч үзэх нь зүйтэй. Учир нь үйлдэгдсэн гэмт хэргээс шалтгаалаад хохирогч нь насан туршдаа хөгжлийн бэрхшээлтэй болох эсхүл насан туршдаа эдгэшгүй өвчин, эмгэгтэй болж болно. Иймд хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг удаашруулж орхиж болохгүй.

¹⁷⁷ А.Лхагва М.Ганхүү Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.,Уб., 2015 он

Дүгнэлт

Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгч гэдэг нь нь ялын хамгийн хатуу төрөл болох хорих ял эдлэх хугацаандаа бусдад учруулсан гэм хор, хүүхдийн тэтгэлэг, бусад төлбөрийг төлөх үүрэг хүлээж буй хоригдол юм. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь хорих ангиудын захиргаа болон Иргэний шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүдийн хамтын ажиллагаа шаардсан ажиллагаа юм.

Хорих ангийн захиргааны зүгээс төлбөртэй хоригдлыг өөрийн үйлдвэрлэл болон гэрээгээр ажиллуулдаг цалинтай ажилд хуваарилан хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийж хоригдлын гүйцэтгэх баримт бичиг байгаа шийдвэр гүйцэтгэх газар хэлтэст шилжүүлэх ажиллагаанд анхаарах. Харин шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс Хорих ангийн захиргаанд найдах бус хоригдлын нэр дээрх мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө, хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгийн талаарх мэдээллийг лавлан тухайн хөрөнгөөс гүйцэтгэх баримт бичигт заагдсан төлбөрийн хэмжээгээр суутгал хийх юм.

Гэвч Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагаа нь сүүлийн 3 жилд дунджаар 0.5%-1.6% биелэлттэй байгаа нь судалгаанаас харагдсан. Энэ нь гэмт хэргийн улмаас бие, сэтгэл санаагаараа хохирсон хохирогчдын хохирол хангалттай хэмжээнд барагдахгүй байгаагийн илрэл юм.

Судлаач миний бие хорих ял эдэлж буй төлбөр төлөгчид холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар судалж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1.Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн дийлэнх хэсэг нь ажлын байраар хангагдаж, хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийлгүүлэх замаар төлбөрөө хэсэгчлэн төлдөг ч төлбөрөө бүрэн барагдуулах тохиолдол цөөн. Хоригдлын хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж байгаа учраас өндөр дүнтэй төлбөртэй хоригдлын төлбөр төлөгдөхгүй удааширч урт хугацааг шаардаж байна.

2. Хорих ангид ял эдэлж буй хоригдлын гэм хорын төлбөрийг ихэнх тохиолдож ар гэрийнхэн нь төлдөг нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь эрүүгийн хуулийн 1.3.3 дугаар зүйлд заасан Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй гэх заалтыг зөрчиж байгаа юм.¹⁷⁸

4. Дийлэнх хорих ял эдэлж буй төлбөр төлөгч нь бусдад учруулсан гэм хороо хурдан төлж, хохирогчийн эрхийг хангах бус зөвхөн өөртөө ашигтай байдлыг харж хорих ялаас хугацааны өмнө суллагдах зорилгоор төлбөрөө төлж байгаа нь эрүүгийн ялын зорилго алдагдахад хүргэж байна.

Дэвшүүлж буй санал:

¹⁷⁸ Эрүүгийн хууль. Уб., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл

1. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийг хорих ангийн зүгээс заавал цалинтай ажлын байраар хангах. Ихэнх хоригдол зан байдлын төлөвшлөөс шалтгаалан ажлын байраар хангагдахгүй байх ба хөдөлмөрөөр хүмүүжүүлэх зарчмыг баримталж ажиллах нь ялын үр нөлөөг нэмэгдүүлнэ.
2. Хорих ангид хөдөлмөр эрхэлж буй хоригдлуудын цалинг дийлэнхийг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулах бус хийсэн хөдөлмөрт тохирсон цалин олгож байх. Хоригдол гэдэг утгаараа нийгмийн амьдралд оролцох эрхээ хасуулсан ч хөдөлмөрийн хөлс авах, түүнийхээ үр шимийг хүртэх эрхийг хязгаарлаж үл болно.
3. Хорих ангид ял эдэлж буй төлбөр төлөгчийн ар гэрийнхнээр төлбөрийг төлүүлэхээс зайлсхийж эд хөрөнгө, мөнгөн хөрөнгөө нуун дарагдуулахаас урьдчилан сэргийлж ажиллах
4. Гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг яагаад төлөх ёстой талаар сургалт зохион байгуулж байх.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

I. Монгол эх сурвалж:

1. С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол II боть” Уб., 2014 он
2. С.Нарангэрэл. “Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг”. Уб., 2021 он
3. “Шийдвэр гүйцэтгэгчийн ном”, Уб., 2020 он
4. Лхагва, М.Ганхүү. “Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”. Уб.2015 он.
5. Л.Чүлтэмсүрэн, А.Лхагва “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар”. Уб.,
6. Ч.Өнөрцэцэг. “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт”, 2022 он
7. С.Буянзаяа, Б.Эрдэнэ-Очир, Ш.Энхжаргал, Б.Болор-Эрдэнэ, Б.Алтангэрэл. Иргэн “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”
8. Ш.Монтескье. “Хуулийн амин сүнс”
9. Д.Баярсайхан. “Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал” 2012 он
10. Н.Гантулга. “Монгол улсын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, 2019 он

II. Гадаад эх сурвалж:

1. А.А.Пионтковский. Основные аспекты теории наказания. 1963 он

III. Бусад эх сурвалж:

1. Үндсэн хууль 1992 он
2. Эрүүгийн хууль 2015 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

---o0o---